

ISSN 2313 8408

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

ГЕОЛОГИЙН АСУУДЛУУД



Дугаар 22 № 01 2023

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ  
БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР  
ГЕОЛОГИ, ГЕОФИЗИКИЙН ТЭНХИМ

**ГЕОЛОГИЙН АСУУДЛУУД**  
**ДУГААР 22 №01**

*Улаанбаатар хот*  
*2023 он*

Монгол Улсын Их Сургууль  
Шинжлэх Ухааны Сургууль  
Геологи, Геофизикийн тэнхим

## Геологийн асуудлууд Дугаар 22 №01

**Сэтгүүлийн редакцийн зөвлөл:**

Ц.Баатарчулуун  
Б.Эрдэнэцогт  
Б.Бат  
Б.Мөнхцэнгэл  
Л.Уранбилэг  
Л.Оюунжаргал  
Х.Уламбадрах

**Дугаарыг эрхэлсэн:** Х.УЛАМБАДРАХ, Л.ОЮУНЖАРГАЛ,  
М.НОМИНЦЭЦЭГ

2000 оноос хэвлэв.

ISSN: 2313-8408

Хавтасны зураг: Энэтхэг-Азийн коллизийн алсын шахалтын эцсийн байршлыг илэрхийлдэг Увс аймгийн Түргэн суман дахь Түргэний хагарал. Монгол Алтайн нурууг хязгаарласан энэ хагарлаас зүүн тийш Их Нуурын хотгор үргэлжилнэ. Гэрэл зургийг Х.Уламбадрах, 2023.

## ГАРЧИГ

- Баруун Монголын юрын хурдсын нас, эртний уур амьсгал, палеоландшафт: палинологийн судалгааны шинэ үр дүн**  
Н.Одгэрэл, Н.Ичинноров, Х.Уламбадрах ..... 6
- Тэлмэн нуурын морфометрийн онцлог, хотгорын морфологи, гарал үүсэл**  
Э.Алтанболд, Х.Уламбадрах, Chun Xi, Li Dingjun, Б.Даариймаа, Б.Батзориг .. 20
- Борзонгийн Говь-50 төслийн талбайн Халзан-уул бүрдлийн U-Рь (SHRIMP  $^{26}\text{Pe}$ ) насны судалгаа**  
Б.Энхбат, С.Оюунгэрэл, Э.Нарангэрэл, Э.Бямбацогт ..... 36
- Увс аймгийн Өндөрхангай суманд орших Дэлтийн Си-Ni-ийн илрэлийн бодисын бүрэлдэхүүний судалгаа**  
Э.Нарангэрэл, С.Оюунгэрэл, Б.Энхбат, Э.Энх-Эрдэнэ ..... 49
- Хойд Элдэвийн ордын нүүрсний петрографийн найрлага, чанарын судалгаа**  
Б.Цэрэнбат, Л.Жаргал ..... 63

## ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Геологийн салбараас 1999 оноос эрхлэн гаргаж ирсэн Геологийн асуудлууд сэтгүүлийн чанар, стандарт шаардлага, нөлөөг нэмэгдүүлэхийн тулд өнөөг хүртэл ихээхэн ажлууд хийгдэж ирлээ. Ялангуяа сүүлийн жилүүдэд МУИС-иас авч хэрэгжүүлсэн эрдэм шинжилгээний сэтгүүлд баримтлах бодлого, шийдвэр томоохон нөлөөг үзүүлж байгааг онцлон тэмдэглэе. Үүний дагуу МУИС-ийн Геологийн асуудлууд сэтгүүлийн байнгын ажиллагаатай цахим систем хэрэглээнд нэвтэрсэн ба өгүүлүүд шуурхай шүүмжлэгчид хүрдэг, хэвлэхэд зөвшөөрөгдсөн өгүүлүүдэд олон улсын код оноогддог болсон, сэтгүүлийн бүх дугаарыг цахим болгон шилжүүлсэн, сэтгүүл цахимаар гарах болсон нь уншигчдад хүрэх нийтлэг боломжийг олгосон зэрэг шинэчлэлүүд хийгдсэн нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл болгох зорилгын эхний алхамууд юм. Мөн олон улсын сэтгүүлийн шаардлагад нийцэхийн тулд сэтгүүлийн дугаар тасрахгүй байх нь нэг шалгуур үзүүлэлт болдог ба энэ нь тухайн сэтгүүл хир уншигчдад хүрч байгаа сэтгүүлийн нөлөөг харуулах үзүүлэлт юм.

МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг дувралын Геологийн асуудлууд сэтгүүлийн дугаарууд жил бүр тасралтгүй гарсаар ээлжит №22 (1), 2023 дугаар та бүхэнд хүрч байна.

Энэ удаагийн дугаар тусгай дугаар биш тул геологийн чиглэл бүрийг хамрахаар өгүүлүүд хэвлэгдэж байна.

**Одгэрэл нар (2023)**-ын өгүүлэл Баруун Монголд өмнө хийгдэж байгаагүй юрын үеийн спор, тоосонцорын судалгаанд зориулагдсан ба үүгээр Хасагт хайрханы нурууны ар, өвөрт байгаа юрын Жаргалант формацад хадгалагдсан ургамлын үлдвэрээс юрыг төлөөлөх спор, тоосонцрыг ялгаж, түүнээс улбаалан тухайн үеийн уур амьсгалын байдлыг сэргээн босгосон байна. Баруун Монголд түгээмэл ялгагддаг Жаргалант формацийн насыг түрүү юр гэж үзэж ирсэнийг спор, тоосонцорын судалгаанаас үндэслэн дунд юр байх боломжтой байна гэх саналыг шинээр дэвшүүлжээ.

**Алтанболд нар (2023)**-ын өгүүлэл Баруун Монголын Тэлмэн нуурын хотгорын гарал үүсэл, морфометрийн онцлогийг хөндөж, тус нуурын хотгор хагаралтай холбоотой болохыг үзүүлсэн байна. Хагарлын дагуу Тэлмэн нуурыг тэжээгч гүний ус байгаа талаарх санааг дэвшүүлсэн ба сүүлийн 20 жилийн Төв Ази, улмаар Монгол Улсад болж байгаа уур амьсгалын дулаарал, хаталт Тэлмэн нуурын талбай, эзэлхүүнд тодорхой өөрчлөлт үзүүлээгүй байгааг нотлон харуулжээ.

**Энхбат нар (2023)**-ын өгүүлэл Өмнөд Монголын Цагаан уулын блокын баруун талд байрлах Халзан Уул гранитын бүрдлийн үнэмлэхүй насыг тодорхойлсон судалгаа юм. Тус гранитын бүрдлийн насыг өмнөх судлаачид триасаас юр хүртэл харилцан адилгүй үзэж ирсэн. Уг судалгаагаар тус гранитын бүрдлийн насыг U-Pb (SHRIMP IIe) аргаар  $223.3 \pm 2.3$  сая жил буюу хожуу триаст үүссэн болохыг тогтоожээ.

Нарангэрэл нар (2023)-ын өгүүлэл Увс аймгийн Өндөрхангай суманд орших Дэлтийн Cu-Ni илрэлийн бодисын бүрэлдэхүүний судалгаанд зориулагдсан. Петрографийн судалгааны үр дүнгээр оливинтой габбро, оливин-пироксентэй габбро голлон тогтоогдож, тэдгээртэй холбоотой хүдэржилтийн 2 үе шат ялгагдсан ба магмын гаралтай хүдэр үүслийн 1-р үе шатанд магнетит, халькопирит, пирротин, пентландит, хромит, сфалерит зэрэг эрдсүүд, гидротермаль 2-р үе шатанд өнгөт эрдсээр үүссэн магнетит, халькозин, ковеллин болон гематит зэрэг эрдсүүд үүссэн болохыг минераграфи, рентген диффрактомерийн судалгааны үр дүнгээр тодорхойлжээ.

Цэрэнбат нар (2023)-ын өгүүлэл Алаг тогоогийн нүүрсний ордын Хойд Элдэвийн хэсгийн нүүрсний чанар, петрографийн судалгааны мацералын найрлага ба бодисын бүрэлдэхүүний судалгаагаар ордын нүүрсний чанар, гарал үүслийг тогтооход зориулагдсан байна. Хойд Элдэвийн нүүрс нь нуур гумусын гарал үүсэлтэй, базаль-фрагментар, фрагментар структуртэй, холимог найрлагатай кларен, дюрент кларены төрлийн нүүрс болох нь судалгаагаар тогтоогджээ.

Тухайн өгүүлүүдийг стандарт шаардлагад нийцүүлэн зохиогчдын дарааллаар ишлэх болохыг зөвлөмж болгож байна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаар, зохиогчдын өгүүлэлтэй холбоотой санал, зөвлөмж, шүүмж байвал МУИС, ШУС-ийн Геологи, Геофизикийн тэнхимд хаяглан ирүүлэхийг хүсье.

Редакцийн зөвлөл